



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/368

Баруун-Урт сум

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 42 дугаар зүйлийн 42.3, 42.4, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 263 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.2.2.й, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг хэрэгжүүлэх сумдын дэд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, зүүн бүсийн аймгуудын Олборлох салбарын ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалтаас гарсан "Олборлох үйлдвэрлэлийн лиценз нь ил, эзэн нь тодорхой, гэрээ нь нээлттэй, шийдвэр нь оролцоотой, иргэд нь мэдэлтэй байх" уриалгыг хэрэгжүүлэх талаар дараах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сумдын дэд зөвлөл Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1.1. Тухайн сумын нутаг дэвсгэрт олгогдсон тусгай зөвшөөрлийн мэдээлэл, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, орон нутагт төлсөн татвар хураамж, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулсан хөрөнгө, хийсэн ажил, үр дүнгийн талаар орон нутаг, иргэдэд ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг ОУИТБС-ын дэд зөвлөлөөр дамжуулан үр дүнтэй зохион байгуулах

1.2. Сумдын нутаг дэвсгэрт хэрэгжих ашигт малтмал, газрын тос эрэх, хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагааны талаарх мэдээллийг хайгуулын ажил эхэлсэн үеэс эхлэн орон нутгийн иргэдэд хүргэж харилцан ойлголцлыг бий болгон хамтран ажиллах

2. Дараах арга хэмжээ авч ажиллахыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн удирдлагад үүрэг болгосугай.

2.1. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэн улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж, хандив тусламж, нөхөн сэргээх ажилд зарцуулсан хөрөнгө, хийсэн ажлын талаарх мэдээллийг

20230608/8

ОУИТБС-ын цахим тайлагналын сүлжээгээр тайлагнаж, иргэдэд ил тод, нээлттэй мэдээлэх

2.2. Аймгийн Засаг даргын баталсан тухайн жилийн мэдээний графикийн дагуу батлагдсан маягт аргачлалаар олборлосон бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, үнэ чанар, санхүүгийн мэдээллийг үнэн зөв гарган баталгаажуулж аймгийн статистикийн хэлтэст тайлагнах

3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх аймаг, сумдын дэд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, чадавхжуулах талаарх арга хэмжээг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг аймгийн дэд зөвлөл (Г.Мөнхзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ